

ХУЛХИЙН АМНЫ МОНГОЛ БУЛШ

А.ОЧИР¹, Ц.ОДБААТАР²

¹ ШУА-ийн Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн


² Монголын Үндэсний Түүхийн Музей,

e-mail: odbaatart@yahoo.com

Түлхүүр үг: Монгол улсын Архангай аймаг, Хотонт сум, Хулхийн ам, XIII-XIV зууны монгол булш, богтаг малгай, алтан чимэглэл

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү өгүүлэлд Монгол-Хятадын хамтарсан экспедицийн малтсан XIII-XIV зууны үед хамаарах 8 булшны малтлагын талаар өгүүллээ. Тэдгээр булшинаас гарсан олдвор хэрэглэгдэхүүнүүд нь XIII-XIV зууны үеийн монгол булшинаас гардаг хэрэглэгдэхүүнүүдтэй ижил байна.

2006 онд Монголын Үндэсний Түүхийн Музей, Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёлын Өв, Археологийн хүрээлэнтэй хамтарсан судалгааны анги Архангай аймгийн Хотонт сумын нутагт Дөрвөлжингүүд хэмээх дурсгалыг малтан судалсан юм.




Зураг 1. Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Хулхийн амны I Дөрвөлжин дэх булшны байрлал

Дөрвөлжингүүд нь эртний Уйгурын (745-840 он) үеийн дурсгалууд аж. Хулхийн ам хэмээх газарт буй нэгэн дөрвөлжинг малтах явцад тэнд хожим нь байгуулсан монгол булшуудыг зайлшгүй малтан судлах шаардлага гарсан тул бид Хулхийн амны I дөрвөлжингийн шороон далан дотор болон далангийн дээр, мөн далангийн гадна зүүн урд нь оршиж агсан монгол булшуудыг малтаж цэвэрлэв. I дөрвөлжинг малтан судлахын өмнө талбайг нь 4x4 м хэмжээтэй секторуудад хуваасан бөгөөд тэндэх монгол булшууд дөрвөлжингийн аль нэг секторуудад хуваагдан байрласан болно. Тэдгээр чулуун дараастай монгол булшуудыг

ХУЛХИЙН АМНЫ МОНГОЛ БУЛШ


баруун хойноос нь эхлэн дугаарлав. Булшны байршлын координатыг тогтоохдоо, Garmin Geko 201 маркийн багажийг ашиглалаа. Малтлагыг булш нэг бүрээр өгүүлье.



Зураг 2. Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Хулхийн амны I Дөрвөлжин дэх булшнуудын байрлал

1-Р БУЛШ.

Хойд уртрагийн 47° 17' 000"
 Зүүн өргөргийн 102° 41' 827"
 Далайн түвшнээс дээш 1518 м



Зураг 3. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 1-р булш.



Зураг 4. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 1-р булшны оршуулга

Хулхийн амны I дөрвөлжингийн шороон хэрмийн дотор дугуй чулуун хүрээтэй булш гурав байв. Тэдгээрийн хамгийн баруун хойд захад орших булшийг 1-р булш хэмээн дугаарлав. Энэ нь 3-р булшнаас хойд зүгт 70 см зайд оршино.

I дөрвөлжингийн хэрмийн дотор LXXXII, LXXXIII секторуудад, голын овгорын зүүн урд байрлана. Булшны дараас чулууг цэвэрлэх явцад ваар савны хагархайн үлдэгдлүүд, ясны зүйлс илэрч олдсон. Тэдгээр зүйлс нь 1-р булшийг эрт цагт тонох явцад хөндөгдөн тарсан бололтой. Булшны дараас нь гол дундаа цөөвтөр жижиг чулуутай, бага зэрэг хонхор байлаа. Булшны дараасыг дунд зэргийн хэмжээтэй чулуугаар үйлдсэн бөгөөд мөн I Дөрвөлжингийн барилгын тоосгоноос нэлээд авч ашиглажээ. Дараасны хэмжээ хойноос урагш 370 см, баруунаас зүүн тийш 450 см. Малтлагын I, II үеийг тус бүр 10 см гүн хийв. Малтлагын III үед нүхний зааг ялгаа төдий л сайн мэдэгдэхгүй байсан тул дахин 10 см-аар үргэлжлүүлэн малтлаа. 34 см-ийн гүнээс булшны нүхний зааг ялгарч эхэлсэн боловч баруун тал нь мэдэгдэхгүй байсан тул бид анхны малтсан газраа баруун тийш 30 см өргөтгөв.


110 см гүнээс авсны шал гарсан. Булшнаас ямар нэгэн эд өлгийн зүйл гарсангүй. Авсны банзан хашлага болон шалыг хийхдээ 2 см орчим зузаантай банзыг зөрүүлэн, төмөр хадаасаар хадсан нь авсны булангийн зарим банзнаас ажиглагдаж байлаа. Авсны урт 161 см, өргөн нь 49 см, өндөр 18 см. Хүнээ толгойгоор нь баруун хойд зүгт 295 хэмд хандуулан оршуулсан байжээ. Малтлага 110 см гүн үргэлжлэв.

2-Р БУЛШ.

Хойд уртрагийн $47^{\circ} 17' 001''$

Зүүн өргөргийн $102^{\circ} 41' 831''$

Далайн түвшнээс дээш 1519 м



Зураг 5. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 2-р булш.

Хулхийн амны I дөрвөлжингийн шороон хэрмийн дотор чулуун хүрээтэй дугуй булш гурав байсны зүүн талын булшийг 2-р булш хэмээн дугаарлав.

Энэ булш нь I дөрвөлжингийн шороон далан дотор, голын овгорын зүүн урд талд LXXXIY, LXXXV, XCIY, XCV секторуудад байрлана. Газрын гадарга дээр баруун хойд болон зүүн урд талдаа томоохон чулуун дараастай, мөн хуучин тоосгоны хагархайг дараас болгон ашиглажээ.

Дугуй цагирган хэлбэртэй боловч баруун хойд буюу газрынхаа дээд талд чулуугүй байлаа. Булшны дээрхи дараас чулуу хойноос урагш 4.4 м, зүүнээс баруун тийш 3.5 м байв. Малтлагын II үе буюу газрын хөрснөөс доош 20 см-ийн гүнд нүхний толбо, зааг сайн ялгарч эхэлсэн нь I дөрвөлжингийн голын овгорыг чиглэсэн 200 см урт, 70 см орчим өргөн байсан бөгөөд нүхний гол дунд жижиг, цөөхөн чулуун дараастай байлаа.

40 см-ийн гүнээс авсны модон хашлага илэрлээ. Хашлагыг нимгэн банзаар хийсэн бөгөөд зүүн талын хашлага өмхөрч алга болжээ. Авс нь ерөнхийдөө урт нарийн бөгөөд авсны толгой талаас модтой барьцалдан зэвэрсэн төмөр хадаас гарч байв.



Зураг 6. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 2-р булшны оршуулга

48 см гүнд авсны хөл талаас хүний зүүн хөлийн хуруунууд анх тавьсан байдлаараа гарч ирэв. Малтлагыг үргэлжлүүлэхэд авсны толгой талаас хүний гавал, дээш сэрдийсэн хавирганы ясны хамт цухуйв. Гавлын яс анатомийнхоо байрлалдаа хэдий ч зүүн шанаагаараа бага зэрэг налсан байдалтай байв. Малтлагыг үргэлжлүүлэхэд нурууны яс, хавирганы яс эмх замбараагүй, цээжин дээрээ овоорсон байдалтай байлаа. 71 см-ийн гүнд гавлын ясны баруун доор буюу чихний орчмоос, ихэд ногоорсон металл ээмэг хатсан чих мэт арьсан зүйлд сүвлээтэй гарч ирлээ. Хүний цээжний орчимд овоорсон яснаас бусад нь анатомынхаа байрлалаараа байлаа. Аарцагны яс нь хугарсан байв. Хүний толгойг баруун хойд зүгт 320 хэмд хандуулан, тэнэгэр байдлаар тавьжээ. Булшны нүхний гүн 91 см байлаа. Авс нь ерөнхийдөө нарийн, урт нь 182 см, өргөн 40 см, өндөр нь 26 см.

ХУЛХИЙН АМНЫ МОНГОЛ БУЛШ



Ээмэг. Хүний хатсан чихэнд сүвлээтэй, зэвэрч ногоорсон, цагирган хэлбэртэй мөнгөн ээмэг. Голч 1,3 см, 0,2 см зузаан.


Зураг 7. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 2-р булшны олдвор. Ээмэг.

3-Р БУЛШ.

Хойд уртрагийн $47^{\circ} 16' 998''$

Зүүн өргөргийн $102^{\circ} 41' 829''$

Далайн түвшнээс дээш 1518 м



Зураг 8. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 3-р булш.

Хулхийн амны I дөрвөлжингийн шороон хэрмийн дотор байгаа чулуун хүрээтэй гурван булшны өмнө талын булш.

Энэ булш нь I дөрвөлжингийн хэрмийн дотор, голын овгорын зүүн урд, ХСII секторт бүхэлдээ, ХСIII секторын баруун тал, СИ секторын хойд талаар байрлана. Дугуй хэлбэртэй бөгөөд баруун хойт талдаа цөөн дараас чулуутай. I дөрвөлжингийн өнгөн хөрсийг цэвэрлэн, малтах явцад 3-р булшны баруун талаар тарж цацагдсан олон тооны ваарны хагархай, хүний ясны жижиг үлдэгдлүүд олдсон юм. 35 см гүнээс эхлэн булшны цээжин талын хэсгээр чулуун дараастай, бусад хэсгээр чулуу

багатай болж ирэв. 50 см-ийн гүнд оршуулгын нүхний зааг бүрэн тодорч, улмаар 53 см-ийн гүнээс авсны банзан таг илрэв. Уг таг нь авсны зүүн, баруун хэсэгтээ үлдсэн, голын хэсгээрээ байхгүй байлаа. Анх нэлээд өргөн банзаар хийсэн байжээ. Тонуулчид авсны тагийг эвдсэн бөгөөд үлдэгдэл хэсэг нь ихэд өмхөрч мууджээ.



Зураг 9. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 3-р булшны оршуулга

Булшны гол дундаас хүний далны яс, авсны цээжин хэсгээс хүний зүүн эгэм, хүзүүний болон хурууны яс илрэв. Авсны дунд хэсгээс зэвэрсэн төмрийн (саадагны төмөр гох?) үлдэгдэл гарав. Өөр эд өлгийн зүйлс гараагүй бөгөөд ихэд тоногджээ. Авсны шал өмхөрч алга болсон бөгөөд авсны урт 205 см, өргөн 48 см, өндөр 30 см байв. Авсны байдлаас үзэхэд нас барсан хүнийхээ толгойг баруун хойд зүгт 330° хэмд хандуулан тавьсан бололтой. Булшны гүн 83 см байв.

Төмөр эдлэл

Хашлаганы баруун хажуу, хүний бүсэлхий орчмоос олдсон. Дэгээ хэлбэртэй, дундуураа хугарсан, ихэд зэвэрсэн байв. Саадагны төмөр гох бололтой.

Хэмжээ 5 x 3.5 x 1 см.



Зураг 10. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 3-р булшны олдвор. Төмөр эдлэл


4-Р БУЛШ.

Хойд уртрагийн 47° 16' 997"

Зүүн өргөргийн 102° 41' 834"

Далайн түвшнээс дээш 1518 м.

Энэ нь Хулхийн амны I дөрвөлжингийн зүүн урд үүдэвч бүхий шороон далангийн дээр, СХII секторын зүүн, СХIII секторын баруун урд хэсэгт байрласан, баруунаас зүүн тийш сунасан гонзгой хэлбэрийн чулуун дараастай булш. Чулуун дараас нь овгор бус нэгэн жигд, дунд зэргийн хэмжээтэй чулуугаар үйлдсэн. Уг



булш бусдыгаа бодвол хэмжээгээр харьцангуй бага, 250 х 180 см хэмжээтэй. Дараас чулууг зайлуулж, 10 см гүн малтахад нүхний ам ялгарч эхлэв. Булшны нүхний хэлбэр нь толгой талдаа өргөн, хөл талруугаа нарийн зууван хэлбэртэй байв. Толгой талдаа нэг үе чулуун дараастай, харин хөл талдаа 2 үе чулуун дараастай байв. Булшны шороо хар саарал өнгөтэй. Малтлагыг дахин 10 см ахиулахад булшны нүхний дээд, доод талаас жижиг хэмжээтэй цөөвтөр чулуу гарав. 36 см-ийн гүнээс, хөл талд, модон авсны өмхөрсөн хэлтэрхий, жижиг төмөр хадаасны хамт гарав. 30 см-ийн гүнд, булшны дээд талаас жижиг хар саарал өнгийн, нимгэн ваарны хагархай, 44 см гүнээс ихэд зэвэрсэн төмөр хадаасны үлдэгдэл илрэв.

Зураг 11. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 4-р булш.



Хөл талын хэсэгт, зүүн хананы орчим гал түлж байсны ул мөр мэдэгдэж байлаа. Нарийн банзаар хийсэн хашлагатай бөгөөд толгой талын зүүн хэсгийн хашлага сайн мэдэгдэхгүй өмхөрсөн байв. 82 см-ийн гүнээс, гавлын яс үл ялиг баруун урд зүг хазайсан байдалтай олдov. Хүнээ толгойгоор нь баруун хойд зүгт 265 хэмд, уулын толгойг чиглүүлэн тавьжээ. Авсны таг дотогш цөмөрч гавлын ясны дээрээс дарж, улмаар гавлын ясыг баруун урагш түрэн, эрүүний ясыг доош даржээ. Шүднүүд нь сугарч тарсан байв. Авсны таг хүний толгой талаас доош аарцагны орчим хүрээд алга болсон, баруун доод хананы банз хажуу тийш гулгаж, хүний хөлний шилбэний ясыг дарсан байна. Авсны тагийг авч доош малтахад хүний яс нь анатомийн байрлалаараа байгаа боловч сарвуу, хөлийн зарим жижиг яснууд бага зэрэг хөдөлсөн байв.

Зураг12. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 4-р булшны оршуулга

Авсны хашлагыг хийхдээ 30 см орчим өргөн, 2-3 см зузаан банзыг босгож, хооронд нь зөрүүлж углуургадан төмөр хадаасаар хадсан байв. Авсны урт 183 см урт, хөл талдаа 45 см өргөн аж. Нас барсан хүнээ гар хөлийг их биеийн дагуу сунгаж, дээш харуулан тэнэгэр байдлаар тавьсан байна (Зураг 12). Хүний өндөр 173 см байна. Уг



булшийг үйлдсэний дараахан тонуулчид толгой талаас нь орж тоносон бололтой бөгөөд малтлагаар ямар нэг онцлог олдвор гараагүй юм. Булшны нүхний гүн 94 см байв.

Ваарын хагархай

Хар саарал гадаргуутай, нарийн ширхэгтэй шавраар хийсэн, шатаалт сайтай. 3 х 2.2 х 0.6 см хэмжээтэй. Ваарны хагархайн нэг захад дусал буюу ухамтай төстэй хээ бүдэгхэн харагдаж байна.

Зураг 13. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 4-р булшны олдвор. Ваарын хагархай

5-Р БУЛШ.


Хойд уртрагийн 47° 16' 005"

Зүүн өргөргийн 102° 41' 847"


Далайн түвшнээс дээш 1518 м.

4-р булшнаас зүүн хойд зүгт 175 см зайд, I дөрвөлжингийн зүүн урд далангийн дээр, СХШ секторт байрласан. Баруунаас зүүн тийш сунасан чулуун дараастай, 3.1 х 1.8 м хэмжээтэй.

Булшны толгой талд дараас болгож тоосгоны хагархайг тавьсан байлаа. 10 см гүн малтахад булшны нүхний зааг ялгарч эхлэв. 50 см гүн болоход нүхний доод талаар байгаа цөөн тоосгыг эс тооцвол өөр дараасгүй болов. 71 см-ийн гүнээс маш муу хадгалагдсан яс, модны жижиг хэлтэрхийнүүд, барилгын ханын шаваас шохойн жижиг үлдэгдэл гарлаа. Булшны нүхний хөл талаас бүдүүн гуалинг хөндийлөн ухаж хийгээд хөмрүүлж тавьсан авсны тагны үлдэгдэл гарлаа. Хүний хөлийн тавхайн ясны хэсэг, нурууны яс, толгойн дээд талаас хусны жижигхэн үйс зэрэг зүйлс гарлаа. Малтлагыг үргэлжлүүлэхэд дотор талыг хөндийлж ухсан гуалин модыг толгой талд хөмрүүлэн тавьсан байсны хэмхэрхий үлдэц, түүний доороос зүүн талын шанаа нь эвдэрсэн хүний гавлын яс гарлаа (Зураг 16).



Зураг 14. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 5-р булшны оршуулга



Зураг 15. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 5-р були

Тонуулчид хүний толгой талаас орж авсыг эвдэхдээ, гавлын ясны зүүн, шанаа орчмыг эвдэлж, зарим ясыг сандаачсан бөгөөд авсны тагийг эвдэн, дийлэнх хэсгийг гаргаж хаяжээ. Авсны тагны өргөн нь толгой талдаа 34 см, 32 см урт, 16 см өндөр, хөл талдаа 40 см өргөн, 40 см урт, 32 см өндөр байна.



Зураг 16. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 5-р булины оршуулга

Газрын гадаргаас доош 79 см-т далны ясны хугархай, хавирга болон хөлийн тавхайн ясны зарим хэсэг илэрч гарлаа. Нас бараачийг дээш харуулан, гарыг их биеийн дагуу сунган, толгойгоор нь баруун хойд зүг 240 хэмд хандуулан тавьжээ. Хүний ихэнх яснууд анхны байрандаа, харин хөл гарын жижиг яснууд нэлээдхөдөлжээ. Хүний гавлын дээр хөмрүүлж тавьсан хөндий гуалингийн өмхөрсөн үлдэгдлийг авмагц маш их муудсан, үйсэн богтаг малгайн үлдэгдэл гарлаа. Уг малгайн үлдэгдэл дотроос маш жижигхэн сувсууд гарав. Булшны нүх 93 см гүн байв.

Богтаг малгайн үлдэгдэл

Толгойд өмсөх хэсгийг бортогоноос нь салгаж, бортогыг оройн хэсгийн хамт толгойн дээд талд хөндлөн тавьсан. Малгайн нийт урт 28 см, өргөн 24 см. Зарим зах ирмэгээр 2-3 давхар оёдлын нүхтэй. Хэврэгшиж муудсан. Богтаг малгай оёдлоороо задарсан бөгөөд зарим газраар 2-3 давхар эгнээгээр хатган оёж байсан нь мэдэгдэж байна. Уг малгайг бор ногоон өнгийн бөс даавуугаар доторлож байсны үлдэц болох ялзарсан даавууны жижиг өөдөс гарав.



Зураг 17. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 5-р булинаас гарсан богтаг малгай




Зураг 18. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 5-р булины олдвор. Сувс

Сувс

Голдоо нүхтэй, цагаан, ногоон, шаргал, хөх өнгөтэй, 60 орчим ширхэг. Маш их хэврэгшиж, бутрамхай болсон. Эдгээр сувсуудыг богтаг малгайд хадан тогтоож байсан бололтой. Эдгээр сувсны диаметр 0.1-0.3 см хэмжээтэй байна.

6-Р БУЛШ.

Хойд уртрагийн 47° 16' 007"
Зүүн өргөргийн 102° 41' 834"
Далайн түвшнээс дээш 1518 м.



Зураг 19. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 6-р були.

Хулхийн амны I дөрвөлжингийн зүүн өмнөд шороон далангийн дээр, СХIY секторт байрлана. Хагас цагираг маягийн чулуун дараастай. Дараас чулуу нь зүүн хойд талдаа голдуу байрласан, өмнө талдаа чулуугүй байв. 20 см гүнээс нүхний зааг бага зэрэг ялгарч эхлэв. Маш их тоногдож, хүний ясыг энд тэндгүй тарааж хаясан байв. Далны яс, хавирга,


шүд, хүзүү, нуруу болон эгэмний ясны үлдэгдлүүд маш замбараагүй байдалтай, анатомийн байрлалаа алдсан төдийгүй ихэнх нь хугарсан байв. 86 см-ийн гүнээс чөмөг, хавирга, дал, нурууны яснууд гарав. Яс болон шүдний байдлаас үзэхэд бага насны хүүхэд бололтой. Шилбэний яс анхны байрлалдаа байснаас баримжаалбал хүнээ толгойгоор нь баруун хойд зүг 315 хэмд хандуулан оршуулжээ. Уг булшнаас хүний яснаас өөр зүйлс гарсангүй (Зураг 7). Эх газрын хөрс 96 см-т тулнаар бид малтлагаа дуусгаж эргүүлэн булав.



Зураг 20. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 6-р булшнаас гарсан хүний яс

7-Р БУЛШ.

Хойд уртрагийн $47^{\circ} 16' 011''$
Зүүн өргөргийн $102^{\circ} 41' 824''$
Далайн түвшнээс дээш 1518 м.




Зураг 21. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р булш

Уг булш I дөрвөлжингийн хэрмийн урд өнцөгт, СХI, СХII секторт оршино. I дөрвөлжингийн өмнө талын шороон далантай залгаж байрлана.

Энэхүү булш нь баруунаас зүүн тийш сунасан зууван цагираг хэлбэрийн чулуун дараастай. Чулуун дараасыг нь ажвал, нэлээд тоногдсон бололтой байлаа. Дараас чулууг цэвэрлэж байх явцад ихэд зэвэрсэн, бүсний арал бололтой, нимгэн хавтгай, дугуй хэлбэртэй төмөр эдлэл, төмөр хадаасны хамт

гарав. 30 см гүнээс баруун зүг чиглэсэн нүхний зааг муухан мэдэгдэж эхлэв. 48 см гүнээс булшны нүхний дээд хэсгээр хүний үйрч тарсан шүд, жижиг ясны хэлтэрхий, хавирганы хугархайнууд, 77 см-ийн гүнээс авсны банзан хашлага гарав. Авсны урт нь 190 см, өргөн нь толгой талдаа 58 см, хөл талдаа 53 см, өндөр нь 35 см, зузаан нь 2 см байв.



Зураг 22. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р бушины оршуулга

Хүний гавлын яс анхны байрлалаас хөдөлж, зүүн тийш болсон, баруун хөлийн дунд чөмөг хөндлөн байрласан зэрэг нь тонуулчдын үйл ажиллагаатай холбоотой. Авсыг хадаж байсан зэвэрсэн төмөр хадаас нэлээд гарав. Зүүн талын хашлаганаас 13 см зайд, 98 см-ийн гүнд жижгэвтэр үйсний тасархай гарлаа. Өөр эд өлгийн зүйлс гарсангүй. Авсны шалыг, 20 см өргөнтэй, 2 см орчим зузаан 3 ширхэг банзаар хийжээ. Байгалийн эх хөрс 100 см-ийн гүнд гарснаар малтлага зогсоов.

Олдворуудыг товч тодорхойлбол:

Төмөр эдлэл


Гонзгой дөрвөлжин сэнжтэй, нимгэн хавтгай, дугуй хэлбэртэй төмөр эдлэл. Сэнж нь хугархай, төмөр хадаасаар их биетэй тавлаж хадсан. Нэг талд алтан утас мэт зүйлс наалдсан. Диаметр нь 4,2 см, гархи 3 х 0,8 см, зузаан нь 0,5 см хэмжээтэй.

Төмөр хадаас

Зэвэрсэн төмөр хадаас 10 орчим гарсан. Хэмжээ нь 3 – 8.5 см урт, голч нь 0.3 – 0.8 см. Зарим хадаас нь дугуй, зарим нь дөрвөлжин хэлбэртэй. Мөн зарим хадаасанд авсны банзан хашлаганы үлдэгдэл наалдсан байв.

Үйсний тасархай

6 х 9 см хэмжээтэй. Зориулалт нь тодорхойгүй.




Зураг 23. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р бушины олдвор.

8-Р БУЛШ.

Хойд уртрагийн 47° 16' 990"
Зүүн өргөргийн 102° 41' 853"
Далайн түвшнээс дээш 1519 м.

Хулхийн амны I дөрвөлжингийн зүүн урд талд, шороон далангийн гадна талд буюу голын овгорын чанх харалдаа, СХХII секторт байрлана.



Зураг 24. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 8-р булш

Баруун хойд зүг чиглэсэн дөрвөлжин хэлбэрийн, овгор чулуун дараастай байв. Чулуун дараасыг цэвэрлэж, газрын өнгөн хөрстэй ижил түвшинд хүртэл малтахад, зүүн урд зүг 260 см, баруун хойд зүг 140 см харьцаатай элсэрхэг саарал өнгөтэй нүхний ором ялгарч харагдав.

Булшны нүхний заагийг барьж доош малтахад, шар шороотой хөрс, сул хайрга гарав. 20 см-ийн гүнээс нарийн төмөр хадаас, 30 см-ийн гүнээс шатсан модны нүүрс бага зэрэг, бог малын ясны жижиг үйрмэг гарав. Булшны нүхний баруун хойд хананд хар саарал өнгийн хөрстэй том чулуурхаг давхарга гарч доош үргэлжилсээр байлаа.

Булшны нүхний хойд хананд, газрын гадаргаас доош 65 см-ийн гүнд, дараас маягийн хавтгай чулуунууд илрэв. Мөн газрын гадаргаас доош 80 см-ийн гүнд, нүхний урд хэсгээс тоосгоны хагархай гарлаа.

90 см-ийн гүнд булшны нүхний хөл талаас байгалийн ургаа чулуутай, жижиг хайргатай, хатуу хэсэг гарсан нь эх хөрс байв. Харин булшны хойд хана олон янзын

хөрсний давхаргаас бүрэлдэж байсан бөгөөд хар саарал өнгөтэй, дараас чулуутай үеийн доор шаргал өнгийн хатуу хөрстэй давхарга гарсан юм. Нүхний баруун хойд хананы дээд хэсэгт 55 х 95 см хэмжээтэй чулуун дараастай хар хүрэн хөрс, мөн доод хэсэгт 90 см-ийн гүнд 65 х 110 см хэмжээтэй хар саарал хөрсний толбо илрэв. Бид эхлээд хойд хананы дээд талын хар саарал өнгөтэй, чулуутай давхрагыг шалгаж үзэхээр, малтлагын талбайг баруун хойд зүг 80 см хэмжээгээр сунгав.

Дээрээс нь өнгөн хөрсийг хуулахад дараас чулуутай үе гарсан бөгөөд эдгээр чулууны ойр орчмоос бод, бог малын ясны хэлтэрхий, хуучин тоосгоны хагархай зэрэг зүйлс гарч байлаа. Үүний доороос хатуу, цайвар шаргал хөрс гарсан бөгөөд эдгээрийн доор нь хар саарал хөрстэй давхарга гарав. Эдгээрээс үзэхэд нүхний хойд ханыг ухаж, хөмөглөн оршуулсан бололтой байв. Малтлагыг баруун хойд зүг үргэлжлүүлэхэд 123 см-ийн гүнээс авсны зэвэрсэн төмөр хадаас, модны жижиг өмхөрсөн хэсгийн хамт гарав.

Баруун хойд хананд, нүхний доод хэсэгт хөндийлөн ухаж, хөмөг гаргаад түүнд хүнээ оршуулсан нь тодорхой болов. Авсны банзан таг нь хүний бүсэлхий орчмоос доош өмхөрч алга болсон бөгөөд хүний толгой талыг газрын өөд ялимгүй өндөрлөж тавьжээ. Нимгэн банзыг хоёр залгаж авсны ханыг хийсэн бөгөөд олон төмөр хадаасаар хадсан байжээ. Авсны банзан тагийг цэвэрлэх явцад хүний аман хүзүүний яс анатомийнхаа байрлалыг алдаж хөдөлсөн байдалтай, таг дээрээс олдлоо. Авсны толгой талаас бог малын далны хугархай яс гарлаа.

Авсны хашлага толгой талдаа 43 см өндөр, урт нь 2 м орчим бөгөөд хүнээ толгойгоор нь баруун хойд зүг 307 хэмд хандуулан тавьжээ. Хүний бүсэлхий орчмоос доош, дунд чөмөгний орчим хэлбэрээ алдаж, задарсан үйсэн эдлэл гарсан нь богтаг малгайн үлдэгдэл бололтой. Үйсэн эдлэлийн зах хөвөөгөөр оёж байсны ул мөр үлдсэн байна. Уг эдлэл хүний өвдөгний үетэй наалдсан байсныг авахад, алтан боронзоор будаж хээлсэн байсан нь мэдэгдэх төдий байв.

Нас барсан хүнд өмсүүлсэн хувцасны тамтаг гарсан нь хар өнгөтэй, алтан саатай торгон дээлний навтархай байв. Уг булшинд мэрэгч амьтад үүрлэж байсны ул мөр болох хулгана зурамны яс болон ялгадас нэлээд байсан бөгөөд тэнд байсан жижиг эдлэл, яс болон богтаг малгай зэргийг зөөж хөдөлгөсөн төдийгүй дээл хувцасыг ихээхэн сүйтгэсэн байна.

Хүний гавал нь авсны модон хашлаганд тулж зүүн тийш ялигүй гилжийсэн бөгөөд эрүүний яс нь авсны зүүн хашлаганы орчмоос олдсон. Хүний өндөр нь 156 см байлаа. Хүний аман хүзүүний яс болон бусад жижиг яснууд хөдөлж, анатомийн байрлалаа алджээ. Хүний яс ерөнхийдөө муу хадгалагдсан бөгөөд биеэр жижигэвтэр, залуухан эмэгтэй хүн байсан бололтой. Аман хүзүүний ясан дээрээс сувд болон оюу чулууг сүвлэсэн, сүүжин хэлбэртэй алтан ээмэг гарсан нь мэрэгч амьтад зөөж тэнд аваачсан бололтой.

Мөн 4 ширхэг алтан товч гарсан нь бүгд анхны байрлалаас хөдөлжээ. Эдгээр товчнууд босоо сэнжтэй бөгөөд элэгдэж мөлийсөн, хонхойсноос үзвэл, удаан эдэлж байжээ.

Гавлын ясны баруун доороос 21 ширхэг цагаан сувд бөөнөөр гарсан нь үсний сувдан даруулга, эсвэл богтаг малгайд хадаж байсан чимэг байж болох юм.



Зураг 25. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 8-р булш.
А. Булшны нүх, Б. Оршуулга (хөл талаас)

Хүний гавлын ясыг авахад дагзны доор наалдсан маш нарийн хийцтэй хавтгай алтан чимэг олдсон. Уг чимэглэлийг даавуун эдлэл дээр оёж тогтоогоод, толгойдоо зангидан хэрэглэж байсан болов уу гэмээр байдалтай байлаа. Хүний зүүн гарын бугалганы орчмын дээлний навтархайг цэвэрлэх явцад гархин хэлбэртэй, жижиг алтан ээмэг гарлаа.

Хүний яс болон дээлний навтархайд дунджаар 1,5 см урттай үс их наалдсан байснаас үзвэл, нас барсан хүнийг үстэй дээлтэй оршуулсан байсан бололтой. Хүнээ оршуулахдаа авсанд тэнэгэр байдлаар дээш харуулан, гарыг их биеийн дагуу сунгаж, хөмөг рүү толгойгоор нь шургуулан хийгээд, үлдсэн сул зайг шороогоор дүүргэж чигжсэн байна. Булшны нүхний гүн 152 см хүрэв.

8-р булшнаас олдсон эд өлгийн зүйлсийг товч тодорхойлбол:

Алтан чимэг. (зураг -1)

Тана, оюу, номин зэрэг чулууг шигтгэсэн зургаан талт, хавтгай алтан чимэглэл. Нүүр талын хавтгайн гурван талд зууван дугуй хэлбэрийн тана суулгасан, эдгээр танан шигтгээний завсарт оюу, номин зэрэг жижиг чулууг тусгай хоногт суулгасан байсны нэг чулуу нь гээгджээ. Гол дундаа үйрмэг цагаан чулуун шигтгээтэй, алтыг цувин, ургамлын гаралтай угалзарсан хээгээр нүүр талыг бүхэлд нь сүлжиж чимэглэсэн. Уг эдлэлийн ирмэгийг хөвөөлдүүлэн жижиг алтан үрлийг нэгэн жигд ойрхон гагнаж эмжсэн. Ар тал нь хавтгай, номин чулууны дээд талд гурван жижиг цоорхойтой. Урт 6.15 см, зузаан 0.3 см, жин 14.7 гр

Сүүжсин хэлбэртэй алтан ээмэг (зураг - 2)


Их биеийг нь алтаар хийсэн, 2 ширхэг сувдыг 1 ширхэг оюу чулууны хамт нарийн цувисан алтаар голоор нь сүвлээд, төгсгөл хэсгийг нь их биед нь ороосон.

Алтан товч (зураг - 3)

Булшны толгой талаас 2 ширхэг, хөл талаас 2 ширхэг, нийт 4 ширхэг олдсон. Босоо, хавтгай сэнжтэй, хөндий. Бөөр нь хонхойсон, нэг товч нь цоорсон. 1 см өндөр, 0,9 см диаметртэй. Товчны бөөрийг тойруулан жижиг үрлүүдийг гурав, гурваар гагнаж наасан.

Гархи хэлбэрийн алтан ээмэг (зураг - 4)

Дээлний зүүн ханцуйны орчмын навтархайг цэвэрлэх явцад олдсон. 1,2 см голчтой, 0,2 см зузаан.



Зураг 26. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р булшны олдвор илэрсэн байдал

Сувд


Нийт 30 ширхэг олдсон. Эдгээрийн 9 нь авсны хөл орчмоор тарсан, бусад нь гавлын ясны баруун доороос гарсан. Хэлбэр хэмжээ нь харилцан адилгүй. Дунджаар 0.5 – 0.6 см голчтой.

Үйсэн эдлэл

Хөлийн дунд чөмөг, өвдөгний тушаа байсан бөгөөд маш муу хадгалагдсан. Зарим үйсэн дээр алтан боронзоор будсан бүдэгхэн хээтэй.

Дээлний навтархай

Шар саатай, хар торгон дээл байсан бололтой. Муу хадгалагдсан.



Зураг 27. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р бушины олдвор 1. Алтан чимэглэл 2. Сүүжин ээмэг 3. Сувд, 4. Гархин ээмэг 5. Алтан товч



Зураг 28. Архангай аймгийн Хотонт сум, Хулхийн амны I Дөрвөлжин, 7-р бушины олдвор. 1. Алтан чимэглэл, 2. Торгон дээлний үлдэгдэл, 3. Үйсэн эдлэл

Хулхийн амны булшны оршуулгын зан үйлийг харьцуулсан хүснэгт *

Булш	Булшны гүн	Хүнээ хандуулсан зүг чиг	Нас	Хүйс	Булшнаас олдсон эд өлгийн зүйлс	Авс
1.	110 см	Баруун хойш (295°)	18-20	Эмэгтэй	Төмөр хадаас	Банзан австай
2.	91 см	Баруун хойш (320°)	18-20	Эмэгтэй	Төмөр хадаас, цагирган хэлбэртэй мөнгөн ээмэг,	Банзан австай
3.	83 см	Баруун хойш (330°)	45-50	Эрэгтэй	Ваарын хагархай, саадагны төмөр гох	Банзан авс
4.	94 см	Баруун зүг (265°)	35-40	Эрэгтэй	Төмөр хадаас, ваарын хагархай, модны нүүрс	Банзан авс
5.	93 см	Баруун зүг (240°)	50-55	Эмэгтэй	Богтаг малгай, сувс	Хөндий гуалин хөмрүүлж тавьсан
6.	96 см	Баруун хойш (315°)	Хүүхэд	-	Төмөр хадаасны үлдэгдэл	Байхгүй
7.	100 см	Баруун хойш (310°)	40-45	Эрэгтэй	Үйсний үлдэгдэл, төмөр хадаас	Банзан австай
8.	152 см	Баруун хойш (307°)	25-30	Эмэгтэй	Хээтэй үйсэн эдлэл, сүүжин хэлбэртэй алтан ээмэг, гархин хэлбэртэй алтан ээмэг, алтан товч 4 ш, сувд 30 ш, толгойн алтан чимэг, торгон дээлний навтархай,	Банзан австай, хөмөглөж оршуулсан

ДУГНЭЛТ

Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хулхийн амны 8 булш нь өдрийн турш нар тусах энгэр газар байрласан бөгөөд дийлэнх булшинд нас барсан хүний толгойг баруун хойд зүгт байгаа уулын оройг чиглүүлэн тавьсан байлаа.

Тэдгээр 8 булшны 7 нь дугуй хэлбэрийн чулуун дараастай, гол дундаа чулуу багатай. Харин 8-р булш гонзгой дөрвөлжин хэлбэртэй, газраас 40 см хэртэй өндөр, чулуун дараастай байлаа.

* Булшнаас гарсан хүний ясанд антропологийн хэмжилт, тодорхойлолт хийсэн МУИС-ын Археологи-Антропологийн тэнхимийн багш Д.Түмэн, М.Эрдэнэ, магистр Ч.Ванчигдаш нарт талархлаа илэрхийлье.

Дийлэнх булш тоногдсон байсан боловч үлдэж хоцорсон зарим нэг олдворуудыг нь дундад зууны монгол булшнаас гардаг олдворуудтай адилтган үзэж болох юм. Тухайлбал, нэлээд хэдэн булшнаас үйсэн эдлэлийн тасархай олдсоны (5, 7, 8-р булш) зарим нь Дундад зууны Монгол эхнэр хүний өмсдөг богтаг малгай болох нь мэдэгдэж байсан юм.

Тэдгээр булшнууд нь он цагийн хувьд ойролцоо үед хамаарах, нэгэн угсаатны оршуулга бололтой хэмээн бид урьдчилан үзэж байна. Эдгээр булшуудыг I дөрвөлжинг байгуулсны дараагаар, XII-XIV зууны үед үйлдсэн бололтой.

Мөн 5-р булшнаас гарсан үйсэн богтаг, түүний жижиг сувснууд нь дундад зууны монгол эмэгтэй хүний булшнаас гардаг олдворын нэг юм. Монгол улсын нутагт малтсан Дундад зууны монгол булшнаас одоогийн байдлаар 24 богтаг малгай гарсан (Эрдэнэбат 2006, 114-р тал) гэх мэдээ бий бөгөөд эдгээр үйсээр хийсэн богтагны заримаас нь шилэн сувсаар хэлхсэн чимэглэл олдсон байна. Хулхийн амны 5-р булшнаас гарсан сувсууд нь хөх, цагаан, шаргал, ногоон өнгөтэй, голдоо нүхтэй 60 гаруй ширхэг байна. Ийм хэлхсэн сувсан чимэглэл Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бурхан толгойн дундад зууны монгол булшнаас гарч байжээ (Эрдэнэбат 2006, 103-129-р тал).

Мөн 8-р булшнаас гарсан хавтгай алтан чимэг нь 2005 онд МУИС-ийн археологийн судалгааны баг Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгой хэмээх газарт малтсан Дундад зууны монгол булшнаас гарсан алтан чимэглэлтэй хэлбэрийн хувьд төстэй, хийц нь адил байна (D.Tumen ба бусад. 51-60-р тал).

8-р булшинд байсан хүний баруун чөмөг, өвдөгний орчмоос задарсан үйсэн эдлэл олдсон нь богтаг малгай байж болох юм хэмээн үзэж байна. Монгол эмэгтэй хүний оршуулгад богтаг малгайг дагалдуулах зан үйлээс ажиглавал, ихэвчлэн толгойд өмсдөг хэсгээс нь салгаж, хүний хөл өвдөг хэсэгт тавьдаг (Эрдэнэбат 2006, 115-116-р тал) зан үйлтэй ижилсэж байна. Нөгөө талаар уг үйсэн дээр үлдсэн, алтан шаргал хээ бүхий богтаг малгайн үлдэгдэл Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг Бургалтайн голын хөндийд малтсан монгол булшнаас гарчээ (Батсайхан нар 2006, 62-63-р тал). Мөн хүний гавлын ясны баруун доороос гарсан сувдан чимэглэлүүд нь богтаг малгайд хадах буюу санчигнаас зүүж байсан чимэглэл байж болох юм. 8-р булшнаас гарсан зургаан талт, хавтгай алтан чимэглэлийг богтаг малгайн урд хэсэгт цоховч болгон хадаж байсан байж болно. Учир нь уг эдлэлийн нэг талд гурван газар нэвт цоолж, ямар нэг зүйлд хадаж, тогтоож байсан ор байгаа ба нөгөө талаас уг чимэглэл дундад зууны монгол эмэгтэйн богтаг малгайн дүрслэлүүдтэй нэлээд төстэй байна. Иймээс бидний малтан судалсан дээрх 8 булш нь XIII-XIV зууны монголчуудын булш мөн хэмээн үзэж байна.

НОМ ЗҮЙ

Батсайхан З, Өлзийбаяр С, 2006. 2005 онд Сэлэнгэ аймгийн нутагт археологийн судалгаа хийсэн тухай. Mongolian journal of Anthropology, Archaeology and Ethnology, vol.2, 1 2 (271):7-66

Очир А, Энхтөр А, Эрдэнэболд Л, Одбаатар Ц, Анхбаяр А, Батбаяр О, 2006. Монгол-БНХАУ-ын хамтарсан археологийн экспедицийн 2006 оны ажлын тайлан. МҮТМ-н номын сан.

Эрдэнэбат У, 2006. Монгол эхнэрийн богтаг малгай. УБ.

Tumen D, Navaan D, Erdene M, 2006. Archaeology of the Mongolian period: A brief introduction. The silk road. Volume 4, Number 1.

SUMMARY

A.Ochir, Ts.Odbaatar

MONGOL TOMBS AT KHULHIIN AM SITE

The Mongolian International Institute for the Study of Nomadic Civilization, and the National Museum of Mongolian History have been collaborating since 2005 with the Inner Mongolian Cultural Heritage and Archaeological Institution of China. We have conducted excavations on the Uighur chamber tombs in Khulhiin Am, Khotont county, Arkhangai province. Besides the excavation of the Uighur sites, we excavated several Mongol tombs. Altogether eight Mongol tombs were excavated, but most of them were looted in ancient times. Mongol people built their tombs on the Uighur site sometime after the 12th century. On the basis of the archaeological findings, such as a woman's birchbark hat – “*bogtag*” and some golden decorations and jewelry similar to 13-14th century Mongol tomb findings, we suggest these tombs to relate to 13-14th century Mongolian people.